

**Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын  
позицийн тайланг боловсруулах заавар**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Энэхүү зааврын зорилго нь Монгол Улсад оруулсан гадаадын хөрөнгө оруулалт болон Монгол Улсаас гадаадад гаргасан хөрөнгө оруулалтын өөрчлөлт, түүний бодит хэмжээг харуулах гадаад хөрөнгө оруулалтын позицийн тайланг боловсруулахад баримтлах үндсэн арга зүйгээр хангахад оршино.

2. "Гадаад хөрөнгө оруулалтын позицийн тайлан" гэж дэлхийн бусад орнуудтай хийсэн бүх төрлийн хөрөнгө оруулалтын гүйлгээгээр үүссэн санхүүгийн гадаад актив, пассивын хэмжээг харуулдаг статистикийн тайланг хэлнэ. Гадаад хөрөнгө оруулалтын санхүүгийн актив, пассивт үнэт цаасаар илэрхийлэгдсэн орийн бичиг, харилцах, хадгаламж, зээл, урьдчилгаа, мөнгөжсөн алт, зээлжих тусгай эрхийн данс, компаний хувьцаа болон санхүүгийн дериватив орно. Хэрвээ зээлдүүлэгч нь буюу өмчлөгч нь Монгол Улсын эдийн засгийн харьяат байвал санхүүгийн гадаад активт, эдийн засгийн харьяат бус байвал санхүүгийн гадаад пассивт тус тус ангилна.

3. Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позици гэж эдийн засгийн харьяат болон харьяат бусын хооронд хөрөнгө оруулалтын харьцаагаар үүссэн санхүүгийн актив, пассивын зөрүүг хэлнэ. Санхүүгийн гадаад активын үлдэгдлээс санхүүгийн гадаад пассивын үлдэгдлийг хасч гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позицийг тодорхойлно.

4. "Эдийн засгийн харьяат" (цаашид харьяат) гэдэгт дараахь ангилалд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийг хэлнэ. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд,
- Гадаад орнуудад 1 жил хүртэл хугацаагаар түр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд,
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр 1 жилээс дээш хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд,
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа дотоод, гадаад болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, Засгийн газрын байгууллага, төрийн бус байгууллага ба тэдгээрийн салбар, төлөөлөгчдийн газар,
- Монгол Улсаас гадаад орнуудад суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол Улсын иргэд, цэргийн албан хаагч гэр бүлийн гишүүдийн хамт,
- Гадаад орнуудад сурч байгаа болон гадаадад урт болон богино хугацаагаар эмчлүүлж буй Монгол Улсын харьяат иргэд.

"Эдийн засгийн харьяат бус" (цаашид харьяат бус) гэдэгт дээрх ангилалд үл хамрагдах гадаад орны болон Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдана.

5. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позицийн тайланг жилийн эцсийн байдлаар сая америк доллараар гаргана.

## **Хоёр. Санхүүгийн актив пассивын ангилал**

Санхүүгийн актив пассивыг шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дериватив, бусад хөрөнгө оруулалт болон нооц актив гэсэн үндсэн 5 төрөлд ангилна. Нөөц активын ангилал нь зөвхөн активын үзүүлэлтэд хамааралтай.

### **1. Шууд хөрөнгө оруулалт**

Шууд хөрөнгө оруулалт гэж харьяат бус нь урт хугацааны (1 жилээс дээш) эдийн засгийн сонирхлын үүднээс үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид хил давуулж нийлүүлэх, хилийн чанадад салбар, харьяа нэгжээ байгуулахыг хэлнэ. Тухайн компани (А компани) хэд хэдэн хөрөнгө нийлүүлэгч компанитай (Б компани, В компани зэрэг) байхаас гадна өөрөө бусад хэд хэдэн компаниудын (Г компани, Д компани зэрэг) хувьцаа эзэмшигч байж болно. Шууд хөрөнгө оруулалтыг урсгалаар нь гарсан болон орсон гэж ангилна. Гадагшаа чиглэсэн хөрөнгө оруулалтыг актив талд, гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтыг пассив талд бүртгэнэ. Хөрөнгийн эх үүсвэрийн төрлөөр нь шууд хөрөнгө оруулалтыг дараахь 2 бүлэгт хувааж бүлэг тус бүрийг авлага, өглөгөөр ялгаж харуулна.

#### **1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө болон буцааж нийлүүлсэн ашиг**

Хувь нийлүүлсэн хөрөнгө гэж тухайн компанид гаднаас орж ирсэн бодит хөрөнгийг хэлнэ. Компаний үйл ажиллагаанаас бий болсон ашгаас ногдох хувийг тухайн хөрөнгө оруулагчийн эзэмшлийн хөрөнгө рүү шилжүүлж бүртгэхийг буцааж нийлүүлсэн ашиг гэнэ. Өөрөөр хэлбэл, шууд хөрөнгө оруулагчид ногдох хувь нийлүүлэгчийн ашгийг компаниас гадагшаа шилжүүлэхгүй тухайн шууд хөрөнгө оруулагчийн нэр дээр буцааж нийлүүлсэн ашиг гэж бүртгэнэ. Тухайн А компани өөрт нь хамтран хөрөнгө нийлүүлэгч Б ба В компаний эзэмшлийн буцааж нийлүүлсэн ашгийг "салбар компанид өгөх өглөг", өөрөө хувьцааг нь эзэмшигч Г ба Д компани дахь өөрийн мэдлийн буцааж нийлүүлсэн ашгийг "салбар компаниас авах авлага" гэж бүртгэлд тусгана. Хэрвээ тухайн компани үйл ажиллагааны алдагдалтай ажилласан бол буцааж нийлүүлсэн хөрөнгө гэдэгт алдагдлыг хасах (-) тэмдэгтэй бүртгэнэ.

#### **1.2 Компани дундын зээл**

Хувь нийлүүлэгч компаниудын хооронд үүссэн зээлийн авлага, өглөгийн үлдэгдлийг шууд хөрөнгө оруулалтын компани дундын зээлийн бүлэгт бүртгэнэ. Тухайн компаний (А компани) өөрт хөрөнгө нийлүүлэгч компаниас (Б компани, В компани) авсан зээлийн үлдэгдлийг "салбар компанид өгөх өглөг", өөрөө хувьцааг нь эзэмшигч компанидаа (Г компани, Д компани) олгосон зээлийн үлдэгдлийг нь "салбар компаниас авах авлага" -г бүртгэнэ.

### **2. Санхүүгийн хөрөнгө оруулалт**

Санхүүгийн хөрөнгө оруулалт гэж харьяатаас гаргасан хувьцаа (удирдлагын саналын эрхгүй), бонд, үнэт цаас, өрийн бичиг, мөнгөний захын хэрэгсэлд харьяат бусын байршуулсан хөрөнгө оруулалтыг буюу харьяат бусаас гаргасан хувьцаа (удирдлагын саналын эрхгүй), бонд, үнэт цаас, өрийн бичиг, мөнгөний захын хэрэгсэлд харьяатын байршуулсан хөрөнгө оруулалтыг ойлгоно. Санхүүгийн хөрөнгө оруулалтыг

зориулалтаар нь хөрөнгийн хувьцаа болон өрийн бичиг гэж ангилж эдийн засгийн 4 сектор тус бүрээр харуулна.

### **2.1 Хоронгийн хувьцаа**

Хувьцаа гэж компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг хэлнэ. Хэрвээ санхүүгийн хөрөнгийн хувьцааны хэмжээ удирдлагын саналын эрх бүхий хэмжээнд хүрмэгц энэ нь санхүүгийн хөрөнгө оруулалтаас шууд хөрөнгө оруулалтад бүртгэгдэнэ.

### **2.2 Өрийн бичиг**

Өрийн бичиг гэж тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсвэл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг хэлнэ. Өрийн бичгийг бонд ба бусад үнэт цаас болон мөнгөний захын хэрэгсэл гэсэн 2 бүлгээр тус тусад нь харуулна.

## **3. Санхүүгийн дериватив**

Санхүүгийн дериватив гэж санхүүгийн суурь бүтээгдхүүний (хүү, гадаад валют, үнэт металл болон бусад бараа бүтээгдхүүн, үнэт цаас) ханшийн өөрчлөлтөөс үүдэн үнэ ханш нь өөрчлөгдөж байдаг дараах хэлцлүүдийг хэлнэ:

- Форвард хэлцэл /Forward/ - гадаад валют буюу үнэт металлыг талуудын хэлцлийн дагуу тохирсон үнээр тодорхой хугацааны дараа худалдан авах /худалдах/ хэлцэл,
- Опшн хэлцэл /Option/ - олон улсын зах дээр аль нэг гадаад валют буюу үнэт металлыг талуудын хэлцлийн дагуу тохирсон ханш, үнээр худалдах буюу худалдан авах эрх,
- Свop хэлцэл /Swap/ - тухайн өдрийн ханшаар гадаад валют буюу үнэт металл худалдан авч (худалдаж) ирээдүйн тохиролцсон ханшаар эргүүлээд худалдах (худалдан авах) арилжааны хоёр хэлцлийг нэг зэрэг гүйцэтгэх хэлцэл.

## **4. Бусад хөрөнгө оруулалт**

Бусад хөрөнгө оруулалтад бүх төрлийн зээл (тухайлбал, арилжааны, хөнгөлөлттэй, урт хугацааны, богино хугацааны, худалдааны зэрэг), дотоодын арилжааны банкуудын гадаадын банкуудад байршуулсан харилцах хадгаламж болон дотоодын арилжааны банкууд дээр байгаа гадаадын банкуудын харилцах, хадгаламж болон бусад актив/пассив орно.

## **5. Нөөц актив**

Нөөц активт Төв банкин дахь гадаад активыг хамруулна. Монголбанкны гадаад цэвэр нөөцийн мэдээнээс гадаад активын дүнг "нөөц актив" гэсэн үзүүлэлтэд авч тавина.

### **Гурав. Гадаад хөрөнгө оруулалтын позицийг тооцох аргачлал**

Гадаад хөрөнгө оруулалтын позицийг дараахь үзүүлэлтээр тооцно. Үүнд: хөрөнгө оруулалтын тайлант хугацааны эхэнд байсан хэмжээ, тайлант хугацааны туршид шинээр

оруулсан буюу буцаан татсан хөрөнгө оруулалтын хэмжээ, үнэ ханшийн болон бусад өөрчлөлтүүд. Гадаад хөрөнгө оруулалтын позицийг тодорхойлохдоо үзүүлэлт тус бүрийн тайлант хугацааны эхний үлдэгдэл дээр тухайн тайлангийн хугацаанд харьяат ба харьяат бусын хооронд хийгдсэн нэмэгдүүлсэн/бууруулсан гүйлгээг бүртгэсний дараа дахин үнэлгээний болон бусад өөрчлөлтийг тусгах аргаар тооцож гаргана (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Гадаад хөрөнгө оруулалтын позицийг тооцох

Хөрөнгө оруулалтын төрөл	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (а)	Гүйлгээ (б)	Үнийн өөрчлөлт (в)	Валютын ханшийн өөрчлөлт (г)	Бусад өөрчлөлт (д)	Эцсийн үлдэгдэл (е) (е=а+б+в+г+д)
Шууд хөрөнгө оруулалт ..... .....							

1. Санхүүгийн деривативын мэдээлэл нь тухайн тайлангийн үеийн зах зээлийн үнээр илэрхийлэгдсэн байна. Харин бусад төрлийн хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайлангийн бүртгэлийн үнээр тусгана.

2. Гүйлгээ гэж харьяат ба харьяат бусын хооронд хөрөнгө оруулалтын зориулалтаар хийгдсэн санхүүгийн мөнгөн шилжүүлгийг хэлнэ. Хөрөнгө оруулалтын нэмэгдүүлсэн гүйлгээг (+) утгаар, бууруулсан гүйлгээг (-) утгаар бүртгэнэ.

3. Гадаад хөрөнгө оруулалтын позицийг тайлангийн хугацааны эцэс дэх зах зээлийн үнэ, валютын ханшаар илэрхийлнэ. Үүний тулд опы эцсийн байдлаар дахин үнэлгээ хийнэ. Дахин үнэлгээ гэж тайлант хугацааны эцсийн зах зээлийн үнэ болон валютын ханшинд шилжүүлэх тооцоог хэлнэ. Тайлангийн хугацааны эхний үлдэгдэл болон шинээр гарсан гүйлгээний аль алинд валютын ханшийн болон зах зээлийн үнийн гэсэн хоёр төрлийн дахин үнэлгээг хийнэ. Дахин үнэлгээг хийхдээ дараахь зарчмыг баримтлана. Үүнд:

*а. Зах зээлийн үнийн дахин үнэлгээ.* Гадаад хөрөнгө оруулалтын позицийг тодорхойлохдоо хөрөнгө оруулалтыг тайлангийн үеийн зах зээлийн үнэд шилжүүлж дахин үнэлэх зарчмыг баримтлана. Үнийн дахин үнэлгээ нь зөвхөн шууд хөрөнгө оруулалтад хамаарна. Гэхдээ шууд хөрөнгө оруулалтын бүлгээс зөвхөн хувьцааны хөрөнгө оруулалтыг л дахин үнэлнэ. Зах зээлийн үнэ нь хөдөлдөггүй тул бусад буюу буцааж нийлүүлсэн ашиг болон компани дундын зээлд дахин үнэлгээ хийхгүй.

Биржид бүртгэлтэй компаний хувьцааг зах зээлийн үнэд шилжүүлдхдээ хувьцааны арилжааны хаалтын ханшийг авна. Хэрвээ хаалтын ханшийн талаар мэдээ авах боломжгүй бол худалдах ба худалдан авах ханшийн дундажийг хэрэглэнэ. Биржид бүртгэлгүй компаний хувьд цэвэр активын үнийг зах зээлийн ханш гэж үзнэ. Нийт активаас нийт пассив болон саналын эрхгүй хувьцааны дүнг хасч цэвэр активын үнийг тогтооно.

*б. Валютын ханшийн дахин үнэлгээ.* Америк доллараас өөр гадаад валютаар хийгдсэн бүх төрлийн хоронго оруулалтанд валютын ханшийн дахин үнэлгээ хийнэ. Тайлангийн хугацааны эхний үлдэгдэл болон гүйлгээний дүнг өөрөөр хэлбэл хүснэгт 1-ийн (а), (б) баганы үзүүлэлтийг тайлангийн эцсийн үеийн буюу 12-р сарын 31-ний валютын ханшинд шилжүүлэн тооцож ханшийн өөрчлөлтөөс гарах зөрүүг (г) баганд тавина. Монголбанкны зарласан тогрөгийн гадаад валюттай харьцах ханшийн тооцоонд ашигласан америк долларын бусад валюттай харьцах жилийн эцсийн ханшийг тайлангийн эцсийн хугацааны ханш болгон авна. Монголбанкаас зарладаггүй валютаар илэрхийлэгдсэн үзүүлэлтүүдийг 12 дугаар сарын 31-ний Ройтерсын ханшийг ашиглаж дахин үнэлгээ хийнэ.

4. Өмчлөлийн болон хоронго оруулалтын ангиллын өөрчлөлтийн улмаас үүссэн зохицуулалтыг бусад өөрчлөлтөд бүртгэнэ. Үүнд:

- Зээлийн өрийг хүчингүй болох,
- Зээлийн өрийн зарим хэсгийг хөнгөлөх,
- Оруулсан хөрөнгөө буцаан татахгүйгээр (100 хувь эсвэл зарим хэсгийг) хамтарсан үйлдвэр, салбар, нэгжээ татан буулгаснаас үүссэн хөрөнгийн өмчлөлийн өөрчлөлт,
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүртгэлийн шинэчилсэн үнэлгээ,
- Хөрөнгө оруулалтын ангилал (шууд хөрөнгө оруулагчаас санхүүгийн хөрөнгө оруулагч эсвэл санхүүгийн хөрөнгө оруулагчаас шууд хөрөнгө оруулагч руу шилжих) өөрчлөгдөх. Эзэмшиж буй хувьцааны хэмжээнээс хамаарч өмнөх тайлангийн үед шууд хөрөнгө оруулагч (санхүүгийн хөрөнгө оруулагч) байсан компани дараагийн тайлангийн үед санхүүгийн хөрөнгө оруулагчийн (шууд хөрөнгө оруулагч) ангилалд шилжих тохиолдол байна. Тухайлбал, өмнөх онд тухайн харьяат бус нь харьяат компаний хувьцаанаас тун бага хэсгийг эзэмшиж байсан учир санхүүгийн хөрөнгө оруулагчийн бүлэгт багтаж байсан бол тайлант онд нэмж хувьцаа худалдаж авснаар түүний хувьцааны хэмжээ үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээнд хүрснээр уг компани шууд хөрөнгө оруулагч компанид тооцогдоно/

5. Хэрвээ тайлант хугацааны туршид тухайн үзүүлэлтээр ямар нэгэн гүйлгээ гараагүй тохиолдолд зөвхөн эхний үлдэгдлийн үнийн болон валютын ханшийн дахин үнэлгээг бусад өөрчлөлтийн хамт тооцож позицийн тайлант гаргана.

#### **Дөрөв. Гадаад хоронго оруулалтын позицийн тайлан, түүнийг боловсруулах хэлбэр**

Гадаад хөрөнгө оруулалтын позицийн тайланд хөрөнгө оруулалтыг санхүүгийн актив болон пассивын ялгаатайгаар хөрөнгө оруулалтын төрлөөр (шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дериватив, бусад хөрөнгө оруулалт) болон эдийн засгийн салбар (төв банк, Засгийн газар, банк санхүүгийн байгууллага, аж ахуйн нэгж)-аар ангилж үзүүлнэ. Монгол Улсын гадаад орнуудад байршуулсан нийг хөрөнгө оруулалтын хэмжээ нь нийт активын дүнг, Монгол Улсад байршиж буй гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нь нийт пассивын дүнг тус тус тодорхойлно. Тайлант дэлгэрэнгүй (хүснэгт 2) болон хураангуй (хүснэгт 3) хэлбэрээр боловсруулна.

1. Гадаад хөрөнгө оруулалтын позицийн дэлгэрэнгүй тайлан (цаашид дэлгэрэнгүй тайлан гэх) нь позицийг үзүүлэлт бүрээр нь өөрөөр хэлбэл тухайн хөрөнгө оруулалтыг тайлант хугацааны эхэнд байсан хэмжээ, тайлангийн хугацаанд шинээр оруулсан буюу

татаж авсан хөрөнгө, үнэ болон валютын ханшийн дахин үнэлгээний өөрчлөлт болон бусад өөрчлөлтөөр нь дэлгэрэнгүй харуулна.

Хүснэгт 2. Гадаад хөрөнгө оруулалтын позицйн дэлгэрэнгүй тайлан  
.....оны 12-р сарын 31-ний байдлаар

(сая ам. доллараар)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Гүйшээ	Өөрчлөлтүүд			Эцсийн үлдэгдэл (e=a+b+v+г+d)
			Үнийн	Валютын ханшийн	Бусад	
	(а)	(б)	(в)	(г)	(д)	
<b>I. АКТИВ (1+2+3+4+5)</b>						
<b>1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)</b>						
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба буцааж нийлүүлсэн ашиг						
1.1.1 Салбар компаниас авах						
1.1.2 Салбар компанид өгөх						
1.2 Бусад хөрөнгө						
1.2.1 Салбар компаниас авах						
1.2.2 Салбар компанид өгөх						
<b>2. Санхүүгийн хөрөнгө оруулалт</b>						
2.1 Хөрөнгийн хувьцаа						
2.1.1 Төв банк						
2.1.2 Засгийн газар						
2.1.3 Банк санхүүгийн байгууллага						
2.1.4 Аж ахуйн нэгж						
2.2 Өрийн бичиг						
2.2.1 Бонд ба үнэт цаас						
2.2.1.1 Төв банк						
2.2.1.2 Засгийн газар						
2.2.1.3 Банк санхүүгийн байгууллага						
2.2.1.4 Аж ахуйн нэгж						
2.2.2 Мөнгөний захын хэргэсэл						
2.2.2.1 Төв банк						
2.2.2.2 Засгийн газар						
2.2.2.3 Банк санхүүгийн байгууллага						
2.2.2.4 Аж ахуйн нэгж						
<b>3. Санхүүгийн дериватив</b>						
3.1 Засгийн газар						
3.2 Банк санхүүгийн байгууллага						
3.3 Аж ахуйн нэгж						
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>						
4.1 Худалдааны зээл						
4.2 Зээл						
4.2.1 Төв банк						
4.2.1.1 Урт хугацааны						
4.2.1.2 Богино хугацааны						
4.2.2 Засгийн газар						
4.2.2.1 Урт хугацааны						
4.2.2.2 Богино хугацааны						

4.2.3 Банк санхүүгийн байгууллага					
4.2.3.1 Урт хугацааны					
4.2.3.2 Богино хугацааны					
4.2.4 Аж ахуйн нэгж					
4.2.4.1 Урт хугацааны					
4.2.4.2 Богино хугацааны					
4.3 Бэлэн мөнгө ба харилцах					
4.4 Бусад актив					
<b>5. Нөөц актив</b>					
5.1 Мөнгөжсөн алт					
5.2 Зээлжих тусгай эрх					
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө(цэв.)					
5.4 Бэлэн валют ба харилцах					
5.5 Үнэт цаас					
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)					
5.7 Бусад нөөц актив					
<b>II. ПАССИВ (6+7+8+9)</b>					
<b>6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)</b>					
6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба буцааж нийлүүлсэн ашиг					
6.1.1 Салбар компаниас авах					
6.1.2 Салбар компанид өгөх					
6.2 Бусад хөрөнгө					
6.2.1 Салбар компаниас авах					
6.2.2 Салбар компанид өгөх					
<b>7. Санхүүгийн хөрөнгө оруулалт</b>					
7.1 Хөрөнгийн хувьцаа					
7.1.1 Төв банк					
7.1.2 Засгийн газар					
7.1.3 Банк санхүүгийн байгууллага					
7.1.4 Аж ахуйн нэгж					
7.2 Өрийн бичиг					
7.2.1 Бонд ба үнэт цаас					
7.2.1.1 Төв банк					
7.2.1.2 Засгийн газар					
7.2.1.3 Банк санхүүгийн байгууллага					
7.2.1.4 Аж ахуйн нэгж					
7.2.2 Мөнгөний захын хэрэгсэл					
7.2.2.1 Төв банк					
7.2.2.2 Засгийн газар					
7.2.2.3 Банк санхүүгийн байгууллага					
7.2.2.4 Аж ахуйн нэгж					
<b>8. Санхүүгийн дериватив</b>					
8.1 Засгийн газар					
8.2 Банк санхүүгийн байгууллага					
8.3 Аж ахуйн нэгж					
<b>9. Бусад хөрөнгө оруулалт</b>					
9.1 Худалдааны зээл					
9.2 Зээл					
9.2.1 Төв банк					

9.2.1.1 Урт хугацааны					
9.2.1.2 Богино хугацааны					
9.2.2 Засгийн газар					
9.2.2.1 Урт хугацааны					
9.2.2.2 Богино хугацааны					
9.2.3 Банк санхүүгийн байгууллага					
9.2.3.1 Урт хугацааны					
9.2.3.2 Богино хугацааны					
9.2.4 Аж ахуйн нэгж					
9.2.4.1 Урт хугацааны					
9.2.4.2 Богино хугацааны					
9.3 Бэлэн мөнгө ба харилцах					
9.4 Бусад пассив					

2. Гадаад хөрөнгө оруулалтын позицитай хураангуй тайлан (цаашид хураангуй тайлан гэх) нь зөвхөн тайлант хугацааны эцсийн байдлаарх хөрөнгө оруулалтын хэмжээг тайлагнан үзүүлнэ. Дэлгэрэнгүй тайлангийн мэдээлэлд үндэслэж хураангуй тайланг боловсруулна. Хураангуй тайланд Монгол улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позицитай нийт хөрөнгө оруулалтаар болон хөрөнгө оруулалтын төрөл бүр дээр тооцож үзүүлнэ.

Хүснэгт 3. Гадаад хөрөнгө оруулалтын позицитай хураангуй тайлан  
.....оны 12-р сарын 31-ний байдлаар

(сая ам. доллараар)

Үзүүлэлт	жилийн дүн	Үзүүлэлт	жилийн дүн
<b>I. АКТИВ (1+2+3+4+5)</b>		<b>II. ПАССИВ (6+7+8+9)</b>	
<b>1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)</b>		<b>6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)</b>	
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба буцааж нийлүүлсэн ашиг		6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба буцааж нийлүүлсэн ашиг	
1.2 Бусад хөрөнгө		6.2 Бусад хөрөнгө	
<b>2. Санхүүгийн хөрөнгө оруулалт</b>		<b>7. Санхүүгийн хөрөнгө оруулалт</b>	
2.1 Хөрөнгийн хувьцаа		7.1 Хөрөнгийн хувьцаа	
2.2 Өрийн бичиг		7.2 Өрийн бичиг	
<b>3. Санхүүгийн дериватив</b>		<b>8. Санхүүгийн дериватив</b>	
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>		<b>9. Бусад хөрөнгө оруулалт</b>	
4.1 Худалдааны зээл		9.1 Худалдааны зээл	
4.2 Зээл		9.2 Зээл	
4.2.1 Төв банк		9.2.1 Төв банк	
4.2.2 Засгийн газар		9.2.2 Засгийн газар	
4.2.3 Банк санхүүгийн байгууллага		9.2.3 Банк санхүүгийн байгууллага	
4.2.4 Аж ахуйн нэгж		9.2.4 Аж ахуйн нэгж	
4.3 Бэлэн мөнгө ба харилцах		9.3 Бэлэн мөнгө ба харилцах	
4.4 Бусад актив		9.4 Бусад пассив	
<b>5. Нөөц актив</b>		Шууд хөрөнгө оруулалт (цэвэр) (1-6)	
5.1 Мөнгөжсөн алт		Санхүүгийн хөрөнгө оруулалт (цэвэр) (2-7)	
5.2 Зээлжих тусгай эрх		Санхүүгийн дериватив (цэвэр) (3-8)	
5.3 ОУВС-д байршуулсан хөр. (цэвэр)		Бусад хөрөнгө оруулалт (цэвэр) (4-9)	
5.4 Бэлэн валют ба харилцах		Нөөц Актив (5)	
5.5 Үнэт цаас		<b>ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР ПОЗИЦИ (I-II)</b>	
5.6 Бусад нөөц актив			

### Тав. Мэдээллийн эх үүсвэр

Гадаад хөрөнгө оруулалтын позицйн дэлгэрэнгүй тайланг боловсруулахад шаардагдах мэдээллийг үндсэн 2 бүлэгт ангилна. Үүнд:

1. Хүснэгт 2-ын (в), (г) баганы үзүүлэлтийг боловсруулахад шаардагдах үнэ, ханшийн холбогдолтой мэдээлэл. Үүнд:

а/ Гадаад, дотоодын хөрөнгийн болон үнэт цаасны биржийн мэдээ,

б/ Ройтерсийн гадаад валютын америк доллартай харьцах ханшийн мэдээ,

в/ Монголбанкны төгрөгийн ханшийн мэдээ

2. Хүснэгт 2-ын (а), (б), (д) баганын үзүүлэлтийг боловсруулахад шаардагдах тухайн хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл, шинээр оруулсан буюу буцаан татаж авсан хөрөнгийн гүйлгээ болон бусад өөрчлөлттэй холбогдолтой мэдээлэл. Энэхүү мэдээллийг Төв банк, Засгийн газар, банк санхүүгийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс цуглуулна. Үүнд:

а/ Төв банкны гадаад санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дериватив, зээл, бусад актив болон гадаад нөөцийн мэдээ,

б/ Засгийн газрын гадаад хөрөнгө оруулалт, санхүүгийн дериватив, зээл, бусад активын мэдээ,

в/ Банк санхүүгийн байгууллагын гадаад шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн дериватив, зээлийн мэдээ,

г/ Аж ахуйн нэгжийн түүвэр судалгаа

**МОНГОЛБАНК**